



"КОРОНАВИРУСТ БОЛОН АМЬСГАЛЫН ЗАМЫН ХҮНД, ХУРЦ ХЭЛБЭРИЙН  
ХАЛДВАРТАЙ ӨВЧТӨНИЙ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ"  
СУРГАЛТ



# ХИЧЭЭЛ: КОВИД-19 ӨВЧТӨН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ДАРААХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХАЛДВАРГҮЙТГЭЛ

Э. ГЭРЭЛЦЭЦЭГ  
АХЛАХ ЗЭРГИЙН ТАРХВАР СУДЛААЧ ЭМЧ,

- ▶ Түргэн тусламжийн болон бусад тээврийн хэрэгслээр өвчтөн тээвэрлэх явцад өвчтөнөөс гарч буй цус, бөөлжис, биеийн бусад шингэн нь бусад зорчиж буй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна гепатит В, С, ХДХВ, МТСА, зэрэг бактерийн болон вирусын халдварт өртөх эрсдэлтэй байдаг.
- ▶ Энэ эрсдлийг багасгахын тулд эдгээр тээврийн хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлэх нь чухал.
- ▶ Эдгээр тээврийн хэрэгсэлд түргэн тусламж, цагдаагийн машин, тээврийн фургон бусад автомашин хамаардаг.

- ▶ Түргэн тусламжийн тээврийн хэрэгслээр КОВИД-19-тай өвчтөнүүдийг тээвэрлэх явцад өөрсдөө халдварт өртөхөөс гадна дараагийн өвчтөндөө халдвар тараах эрсдэлтэй байдаг.
- ▶ Үүний жишээ: сорьц тээвэрлэсэн болон өвчтөн тээвэрлэсэн ЭМА-д халдварт өртсөн байна.
- ▶ АНУ-ын Өвчний хяналтын төвөөс тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн удирдамжийг гаргасан бөгөөд уг удирдамжийг хэрэгжүүлэх нь ЭМА-ын аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юмаа.

- ▶ Тээврийн хэрэгслийг цэвэрлэж буй ажилчид хамгаалах хувцас, хэрэгслүүдийг өмсөнө.
- ▶ Бээлий, угаалгын нунтаг бүхий цэвэрлэгээний бодис хийх сав, халдваргүйжүүлэх уусмал хийх сав, цэвэрлэгээ хийх алчуур, хог хаягдлын сав, хогны уут, цэвэрлэгээний материал агуулах сагс зэргийг бэлтгэсэн байна.



- ▶ Хүний гар хүрдэг гадаргууг ээлж бүрийн эхэн ба төгсгөлд, мөн өвчтөн тээвэрлэх хооронд цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Цэвэрлэх үед хангалттай агааржуулалт хийнэ. /хаалга, цонх онгойлгох /
- ▶ Агаарын хангалттай хэмжээний солилцуулалт хийхийн тулд тээврийн хэрэгслийн арын хаалгыг онгорхой байлгана.



# Цэвэрлэгээ, халдваргүйтгэл

- ▶ Тээврийн хэрэгслийн суудал, түшлэг, хаалганы бариул, хамгаалах бүс, хаалга, цонх, бариул зэргийг халдваргүйжүүлэхээс өмнө угаалгын нунтаг эсвэл ил харагдахуйц бохирдсон бол савантай усаар угаана.
- ▶ Бусад гадаргууг халдваргүйжүүлэх гэр ахуйн цайруулагч уусмал, 70 хувийн спиртын уусмалыг хэрэглэн халдваргүйжүүлнэ. Хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй.
- ▶ Даавуун суудал гэх мэт зөөлөн гадаргуугийн харагдахуйц бохирдлыг арилгаж, эдгээр гадаргуу дээр тохирсон бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.
- ▶ Таблет эсвэл мэдрэгчтэй дэлгэц гэх мэт байнга хүрдэг электрон гадаргуугийн хувьд харагдахуйц шороог зайлуулж, дараа нь үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлнэ. Хэрэв зааварчилгаа байхгүй бол 70% -ийн спиртийн уусмалаар шүршиж арчина.

- ▶ Цэвэрлэх, халдваргүйжүүлэх явцад хэрэглэсэн бээлий болон бусад нэг удаагийн ХХХ-ийг зөв тайлж хаяна.
- ▶ Бээлий тайлсаны дараа гарыг 30 секундын турш савантай усаар угаана. эсвэл 70% -иас доошгүй спирттэй гар халдваргүйжүүлэгч хэрэглэнэ.
- ▶ Хэрэв нэг удаагийн халад өмсөөгүй бол цэвэрлэгээ хийхэд ашиглаж байсан ажлын хувцасыг угаалгын нунтаг бүхий халуун бүлээн усаар угаана.

# Халдвараас сэргийлэх дэглэм

- ▶ COVID-19-тэй гэж сэжиглэгдэж, батлагдсан зорчигч тээвэрлэхдээ жолооч нь нүүрний хаалт, N95 шүүлтүүртэй амны хаалт зүүнэ.
- ▶ Нүүрний хаалт, нүдний шил нь тээврийн хэрэгсэл жолоодох үед цантахгүй, ямар нэгэн байдлаар аюул учруулах эрсдэлгүй бол зүүнэ.
- ▶ Зорчигчид амны хаалт зүүсэн байна. (2-оос доош насны хүүхдүүд, амьсгалахад хэцүү байгаа, эсвэл ухаангүй зүүхгүй)
- ▶ Зорчигчдыг аль болох бие биенээс нь зайтай суулгахыг хичээх хэрэгтэй.
- ▶ Жолооч нар "өөр маршрутаар явахгүй, олон зорчигч авахаас зайлсхийх" хэрэгтэй. Мөн гарын эрүүл ахуйг тогтмол сахиж, ам, хамар, нүдэндээ хүрэхээс зайлсхийх хэрэгтэй.



# 5 алхам

1. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх заавар, журамтай байх, түүнийг үнэлэх
2. ХХХ-ийг зөв хэрэглэх
3. Халдваргүйжүүлэх бодисыг зөв сонгох
4. Машины тоног төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх
5. Хангалттай агаар сэлгэлт хийх

- ▶ Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх заавар, журам
- ▶ Түргэний машины цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг ЭМС-ын 537-р тушаал, 227-р тушаалын дагуу гүйцэтгэн хийнэ.

# Түргэн тусламжийн машины цэвэрлэгээ ЭМС-ын 537, 227-р тушаал

- Түргэн тусламжийн машиныг 14 хоногт машины дотор, гадна тал, шал, хана, ор, сандал, бусад гадаргууг маш сайн цэвэрлэн их цэвэрлэгээг хийнэ.
- Тээврийн хэрэгслийн кабины хэсгийг / жолооч, ЭМА суусан / эхлээд цэвэрлэж, халдваргүйжүүлж дараа нь өвчтөний гар хүрэлцдэг гадаргууг цэвэрлэн, халдваргүйтгэнэ.
- Дуудлага хооронд түргэн тусламжийн машины гадаргууг халдваргүйжүүлэн цэвэрлэх. Үүнд: Үйлчлүүлэгчийн хэсэгт хүрэлцэх гадаргууд халдваргүйжүүлэх уусмалаар гадаргууг арчих болон шүрших халдваргүйжүүлэлт хийнэ.
- Ариутгалын ажилтан, тархвар судлаачаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.

# Хамгаалах хувцас хэрэгсэл

- ▶ Хамгаалалтын хувцас нь халдвар дамжих замуудыг хааж , өвчин үүсгэгч халдварлах боломжийг зогсоох хамгаалалт болж байдаг.

# Хамгаалах хувцас зөв хэрэглэх

- ▶ Халдваргүйтгэл хийх үед зайлшгүй хамгаалалтын хувцас өмссөн байх хэрэгтэй.

Халдваргүйтгэлийн бодисонд тэсвэртэй бээлий




Хамгаалалтын нүдний шил, нүүрний хаалт

Ус нэвтрэхгүй, халдваргүйтгэлийн бодисонд тэсвэртэй хормогч

Ус нэвтрэхгүй, бодисонд тэсвэртэй гутал

# 24 цаг ажилласны дараа хамгаалалтын хувцас дээрхи бохирдол



Ажил эхлэхийн өмнө хамгаалалтын  
хувцаснаас авсан сорьц



24 цагийн дараа буюу ажил дууссаны дараа  
авсан сорьц

- ▶ Халдваргүйжүүлэх бодис :
- ▶ Халдваргүйтгэл нь химийн найрлага нь ондоо олон төрлийн бодисыг ашигладаг.
- ▶ Ажлын байран дээр гар халдваргүйжүүлэгч, гадаргуу халдваргүйтгэгч, тоног төхөөрөмж, багаж халдваргүйтгэгч гэж тус тусад нь ангилдаг.

## ▶ Цэвэрлэгээ:

- Тодорхойлолт: Ус болон халдваргүйтгэх бодисын тусламжтай хийгдэж байгаа бохирдлыг халдваргүйтгэх үйл явцыг хэлнэ. Нян болон бусад бичил биетийг цөөрүүлэх, устгах, халдваргүйтгэлийн бодисгүйгээр цэвэрлэгээ хийж болохгүй.
- Үр дүн: Бичил биетийг 50-80 %-г устгана.





- ▶ **Халдваргүйтгэл:**
- ▶ Тодорхойлолт: тухайн орчинд халдвар тархах үйл явцыг зогсоох зорилготойгоор бичил биетийг устган үгүй хийх , тэднийг идэвхгүй болгох үйл явц юм.
- ▶ Үр дүн: Бичил биетийн 84-99,9 %-г устгана.




- ▶ Цэвэрлэгээ болон халдваргүйтгэлийн явцад гадаргуу дээрхи бичил биет устан үгүй болно.
- ▶ Цэвэрлэгээ нь Бичил биетийг 50-80 %-г устгадаг.
- ▶ Халдваргүйтгэл нь Бичил биетийн 84-99,9 %-г устгадаг.

Цэвэрлэгээний өмнө


Цэвэрлэгээний дараа

Халдваргүйтгэлийн дараа


Worin unterscheidet sich die Reinigung von einer wirksamen Desinfektion:



**Vor der Reinigung:  
Viele lebende Keime**



**Nach der Reinigung:  
Allgemeine Keimre-  
duktion**



**Nach der  
Desinfektion:  
Abtötung aller Keime**

## Түргэн тусламжийн машины халдваргүйтгэлийн явц


Халдваргүйтгэлийн явц	тайлбар
Нэг цэгт чиглэсэн халдваргүйтгэл	Хурдан хугацаанд цус, бөөлжис, цэр гэх мэт болсон хэсэг газрыг цэвэрлэнэ. Жнь: Халдваргүйтгэлийн бодис хийсэн уусмалд норгосон алчуураар
Тээвэрлэлтийн дараах халдваргүйтгэл ( эцсийн шатны халдваргүйтгэл)	Халдваргүйтгэлийг өвчтөн тээвэрслэсний дараагаар заавал хийх бөгөөд бүх гар хүрсэн хэсгүүдийг ахин халдваргүйтгэнэ.
Өдөр тутмын халдваргүйтгэл ( тогтмол халдваргүйтгэл)	Ажил дуусахад өдөр тутмын халдваргүйтгэлийг тэрэгний дотор талын бүх гадаргууг чийгтэй цэвэрлэгээ хийн халдваргүйтгэнэ.
Халдварт өвчтэй хүн тээвэрлэсний дараах халдваргүйтгэл	Өвчтөн тээвэрлэх болгонд хүчтэй халдваргүйтгэгчээр халдваргүйтгэж, нян, вирусд үйлчлэх хугацааг нарийн мөрдөх хэрэгтэй.

# Гадаргуугын халдваргүйтгэл

- ▶ Гадаргуугын халдваргүйтгэлд бүх төрлийн гадаргууг (ж нь: тоног төхөөрөмж, өвчтөн зөөдөг дамнуурга, шал гэх мэт) Халдваргүйтгэлийн бодистой уусмалд сайтар норгосон алчуураар хөнгөн дарж арчина.
- ▶ Алчуурыг сайтар норгосноор гадаргуу дээр тогтсон бохирдлыг нэгэн жигд халдваргүйтгэн цэвэрлэдэг. Халдваргүйтгэл бүрэн гүйцэт хийгдэж, гадаргуу хатсаны дараагаар өвчтөнийг зөөн тээвэрлэж болно. Халдваргүйтгэлийн хугацаа дуусаагүй бол хүлээх хэрэгтэй.

# Гадаргуугын халдваргүйтгэл

- ▶ Шүрших халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэх явцад амьсгалаар дамжин биед орох аюултайг анхаарах хэрэгтэй. Шүрших нь нийт гадаргуу дээр жигд хэмжээтэй шүршигдэдгүй. Шүрших халдваргүйтгэлийг зөвхөн алчуур хүрч цэвэрлэх боломжгүй газрууд руу шүршиж халдваргүйтгэнэ.
- ▶ (жнь: эвхэгддэг насилкны нугас, завсар луу шүршинэ)



# Гадаргуугын халдваргүйтгэл

- Гадаргууг хангалттай норгосон халдваргүйтгэлийн бодистой алчуураар хөнгөн дарж цэвэрлэнэ.
- Гадаргууг бүхэлд нь хамруулж, зай үлдээхгүйн тулд 8-н тоо хэлбэрээр арчих үйлдлийг хийнэ.
- Халдваргүйтгэлийн бодис агуулсан цэвэрлэгээний усыг нэг өдөр хэрэглэж болдог ба бохирдсон бол шинээр найруулж хэрэглэнэ.

# Нэг хувингийн аргачлал

- ▶ Нэг хувингийн аргачлал гэдэг нь халдваргүйтгэлийн бодисоор дүүргэсэн нэг хувингаар цэвэрлэгээ хийхийг хэлнэ. Ус хэт бохирдсоноос болж халдваргүйтгэлийн бодисын чанарт өөрчлөлт орох сөрөг нөлөөтэй тул нэг хэрэглэсэн алчуурыг дахин халдваргүйтгэлийн бодистой хувинд хийж болохгүйг анхаарна уу. Арчих болгондоо шинэ эсвэл цэвэр алчуур хэрэглэнэ.



# Хоёр хувингийн аргачлал

Хоёр хувингийн аргачлал гэдэг нь халдваргүйтгэлийн бодисоор дүүргэсэн өөр өнгийн хоёр хувингийн тусламжтайгаар халдваргүйтгэх ажлыг хийх явц юм.

- ▶ Эхний хувинтай халдваргүйтгэлийн бодистой усанд алчуурыг сайтар норгон гадаргууг сайтар үрж цэвэрлэнэ.
- ▶ Хоёр дахь хувинд бохирдсон болон хэрэглэсэн алчуурыг хийж сайтар үрж угааж , базаж гаргасны дараагаар ахин эхний хувинд хийж халдваргүйтгэлийн ажлыг цааш үргэлжлүүлнэ.








Халдваргүйтгэлийн бодистой бохирын хувин

Халдваргүйтгэлийн бодистой цэврийн хувин

- ▶ Цэвэрлэгээний хувин , цэвэрлэгээнд хэрэглэсэн бусад зүйлсийг цэвэрлэгээний дараа сайтар цэвэрлэн халдваргүйтгэж хатаана.




# ТҮРГЭН ТУСЛАМЖЫН ТЭРГЭН ДОТОРХИ БҮХ ЗҮЙЛИЙГ ГАРГАХ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ГАРГАХ




## ▶ Тэрэгний дотор талыг дээрээс доош нь чиглэлтэй халдваргүйтгэнэ.

- 1 тааз болон дээд хэсэг
- 2 хана , хүрээ
- 2 шал



- ▶ Гар хүрсэн бүх гадаргууг халдваргүйтгэнэ.
- ▶ Эмнэлгийн тоног төхөөрөмжийг тэргэнд буцаан байрлуулахын өмнө тэдгээрийг мөн адил гадна талыг нь халдваргүйтгэнэ.



- ▶ Машинд байрлуулсан эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зузаан гялгар уутанд хийж хадгална, ингэснээр тоос шороо, бохирдлоос хамгаалж чадах бөгөөд гадна талаас нь алчуураар арчин халдваргүйтгэнэ. Бохирдсон эсвэл хэрэглэсэн багаж хэрэгслийг халдваргүйтгэлд өгч халдваргүйтгэнэ.





# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА